

Соёл урлаг

АНУ-ЫН ТЕАТРУУД

С. Дашдондог
Театр судлаач

Нью-Йорк хотын домогт театрын нэг болох Бродвейн театр Америкийн тайзны урлагийн од байсан цаг холгүй билээ. Энд шинэ жүжгүүд төрж, тайзны мастеруудын нэр цуурайтаж, улс орны хамгийн авьяаслаг уран бүтээлчид өөрсдийн уран чадвараа үзүүлэх цорын ганц боломжийг олгодог байв.

Гэтэл цөөн 10 жилийн хугацаанд энэ бүх байдал өөрчлөгдөж, Бродвейн үзэгчдийн танхим үзэгчдээр дүүрэн байсан тэр цаг улирчээ. Улс орон дөвөр мэргэжлийн театруудын хэлхээ бий болж Америкийг театрийн урлагийн цөм болж байсан Бродвейн байдлыг ганхуулж эхлэв.

Цөөн хэдэн хүмүүс одоо ч гэсэн америкийн театрын тэргүүний байр суурийг хамгаалж, улс орны хамгийн сайн жүжгийн тавилттай хүчирхэг театр нь ганц Бродвей хэвээр үлдсэн гэж маргаж магадгүй юм. Гэрэл үүсэл, бүтээл туурвил, урлагийн төвшинөөр Бродвей театрын түүхнээ их үүрэг гүйцэтгэсэн нь үнэн боловч урьдын адил нэр хүнд бүхий цорын ганц дэвжээ байхаа больсон нь одоо тодорхой байна. Шинэ театрууд аажим боловч өөрсдийн байр сууриа баттайгаар эзэлж, Бродвейтэй өрсөлдөх чадвар бүхий болж, тус бүрийн улирлын тоглолтуудаа Нью-Йорк хотноо тогтмол хийдэг боллоо. Тухайлбал баруун зүгт орших Сизл Репретиор театр нь америкийн жүжгийн урлагийн хөгжлийн нэгэн гэрч болж, америкийн театрийг дэлхийд танилцуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. 1988 онд Венди Васерштeины "Хөйдийн он дарааллын бичиг" гэдэг орчин үеийн амьдралд эмэгтэйчүүдийн эрхийн тухай жүжгээрээ алдаршсан байна. Энэ жүжгээ Нью-Йорк хотноо тоглож, улирлын хамгийн сайн жүжгийн хоёр төрлийн дээд шагналыг хүртжээ. Баруун өмнө зүгийн Техас мужийн Хьюстон хотын Аллей театрт гадаад орнуудын, тухайлбал Вильнюс хотын театр Чеховыг "Нагац Ваня" жүжгийг үзүүлж амжилт олжээ. Түүнчлэн Америк, Канадын 17 хотоор тоглосон Гибсоны "Гайхамшигт ажилчин" жүжиг нь үзэгчдийн таацгаал хүлээсэн байна. Өмнө зүгийн Флорида мужийн Асоло театрт алдарт "Сиднейс Дэ Бержерак"-ийг тавьсан байна.

"Шотландын жүжгийн байшин" хэмээх ордныг дахин сэргээж, орчин үеийн техник хэрэгслээр тоноглогдсон шинэ театрын нээлтийг Флорида мужид дахин тэмдэглэжээ.

Нью-Йорк хотоос холгүй Коннектикут мужийн Хартфорд компаний шинэ тавилт Генрих Ибсены "Төр-Гунт" жүжгээр урын сангаа баяжуулсан байна. Харин энэ жүжгийг Бродвейн театр урьд өмнө тавьж зурхлээгүйг хэлэх хэрэгтэй юм.

Америкийн зохиолч Жерри Стернерийн "Бусад хүмүүсийн зоос" гэдэг америкийн хөрөнгийн бирж, зах зээлийн том жүжиг хөрөнгөтний тухай инээдэмт жүжиг зэргийн тавилтыг нэрлэж болно.

Лос-Анжелесийн Марктапер Форум театрт Америк болон олон улсын чанартай жүжгийн өргөн хөтөлбөр толилогддог ажээ. Энэ бол Америкийн цөөхөн хэдэн газарт болж байгаа зүйлийн нэгэн жишээ юм.

Нью-Йоркт төвлөрсөн онцгой эрх бүхий тайзыг олон хот, мужийн театрын сүлжээнд оруулсан нь хамгийн ашигтай зүйл болжээ. Хорин таван жилийн өмнө гэхэд л бүс нутгийн театрууд Бродвейн тавилтаас шалтгаалж, өөрсдийн сонголтыг хийх эсвэл шинэ жүжиг тавих эрх тэр бүр байдаггүйгээс хөдөөгийн театрууд хоцрогдмол байсан нь улт билээ. Одоо байдал эсрэг болон олон янзын тэтгэлэг олгох ивээн тэтгэгч байгууллага, хувь хүмүүс, орон нутгийн хамтын ажиллагаанаас үүдэн үзэгчдийн тоо олшрон, билетийн худалдаа өргөжиж, америк театрын уран бүтээлийн нэгэн том машины гол хөдөлгүүрийг бүрэлдүүлж жолоодох тийм боломжийг бүс нутгийн театрууд олж авчээ.

Энэ хөдөлгөөний төвд жүжгийн зохиол бичих, арга барилаа эзэмших, магадгүй гол зүйл болсон зохиолч, жүжигчин, найруулагч, техникийн хүмүүсийг зах зээлд орох хүрээг тэлж өгснөөрөө энэ үйл ажиллагаа амжилтанд хүрчээ. Одоо бол бүс нутгийн театрууд нь хүчээ авсан, сая сая үзэгчидтэй, том хүн, хүүхдийн нас ялгааарласан тусгай төлөвлөсөн хөтөлбөртэй, орон нутгийн оршин суугчид өөрсдөө энэ байгууллагыг асран хамгаалж хөгжүүлэх сонирхолтой болсон байна. Залуу авьяастныг тэтгэн уран бүтээлээрээ хөгжиж бололцоо хийгээд амьдрах цалин хөлсийг нь олгож байна. Мэргэжлийн бүтээлчдийг урин улирлын чанартай туршилт хийж байна. Тэднийг орчин үеийн тайзны тоноглол, гэрэлтүүлэгч зэрэг бүх зүйлээр хангаснаар, мужийн театрууд нь Бродвейн бүх салбаруудыг нийлүүлснээс илүү орон тоотой болжээ.

Танилцуулга, мэдээлэл

НИЙСЛЭЛ ВАШИНГТОН ХОТ

Потомак, Анакостия 2 голын сав газар, Мериленд, Виржиния мужуудын дунд орших Вашингтон хот нь АНУ-ын Нийслэл юм. Цэвэр цэмигэр гудамж талбайтай, удам газар нутагтай, уужуу тайван амьдралын хэмнэлтэй Вашингтон хотын тоо томшгүй ногоон зүлэг, цэцэрлэгт хүрээлэн нь туйлуу болон чулуун барилгыг чимж, өнгө үзэмж нэмдэгээрээ бусад хотуудаас эрс ялгаатай.

Вашингтон хотын түүх нийслэл хотын үүрэгтэй нягт холбоотой. Улс гүрний чухал хот хаана байрлах тухай Конгрессийн 7 жилийн маргааны дараа 1793 онд Капитолийн барилгын үндэс суурь анх энд тавигджээ. Францын нэгэн цэрэг Пьер Ленфант инженер, мөрөөдөгч байсны хувьд уг хотыг хэд хэдэн хэсэг өргөн чөлөө, хүрээ тойрогт хуваан төлөвлөх санаачлага гаргажээ. Вашингтон хот маш сүрлэг байхаар төлөвлөгдсөн ч хотын өсөлт хурдац муутай байлаа. 1812 оны дайнд Британы цэрэг Вашингтонд нэвтрэн орж барилга байгууламжийг галдан шатааж, хотын хөгжилт цэцэглэлт зогссон байна. Ерөнхийлөгчийн ордонг сэргээн засварлах үед галын улмаас шатаж харласан өнгөн талын хэсгийг цагаан будгаар шохойдсон тул Цагаан ордон хэмээх нэрийг олжээ. Удаан хэдий ч жигдхэн өсөн өндийж байсан хот иргэний дайн дэгдэх тэр эмгэнэлт үед 75000 оршин суугчтай болжээ. Түүхийн хүрдэнд эргэлдэх олон төрлийн ноцтой асуудал нүүрлэх тэр үед Ерөнхийлөгч Линкольн энэ хотоос мэргэн удирдамжаа гаргаж улсүндэстнийг зөрөлдөн мөргөлдөхөөс аварч гарчээ.

Вашингтон хотын гол үйл ажиллагаа бол дотоод, гадаадын улс төрийн бодлого юм. Уугуул болон гадаадын, албаны бслон жуулчны журмаар ирсэн баян, ядуу, алдартай, огт танихгүй хэн боловч төр засгийн амин судас болсон энэ хотод цуглардаг. 1974 он хүртэл хотыг Конгрессийн зүгээс удирдаж байв. Түүнээс хойш хотын дотоод дүрэм өсоор хотын захирагчийн зөвлөл хэмээх засаглалын хэлбэр сонгогдох болжээ. Гэвч засгийн газар хотын дотоод хэргийг одоо хүртэл хянасан хэвээр байна. Конгресст суугаа дүүргийн цорын ганц төлөөний хүн нь таслах эрхгүй ажээ.

Улс гүрний шийдвэрт нөлөөлөх судалгаа шинжилгээ, яриа, хэлцэл, тогтоол заавар бүгдийг бий болгодог янз бүрийн яс үндэс, үзэл сонирхол, чиглэл зорилгын хүмүүс цугларан төвлөрдөг хот нь Вашингтон юм. Энэ хот засаг захиргаа, хууль, эрх үүргийн аль талаасаа АНУ-ын нийслэл хот мөн.

1989 оны 1-р сарын 1-н байдлаар Вашингтон хотын хүн ам хотын дэргэдэх гацаануудыг оролцуулахгүйгээр 626 мянга байв.

НЬЮ-ЙОРК ХОТ

Нью-Йорк хот нь Америкийн томоохон хот, тэнгисийн боомтын хувьд бизнес, санхүү, харилцаа холбоо, үйлдвэр үйлчилгээ, соёл урлагийн төв хийгээд хээнцэр дэгжин маяг сурталчлах үндэстний тэргүүлэх төлөөлөгчийн нэг мөн. Нью-Йорк хотын үүсэн бий болох тэр үеэс эхлэн улс орны гол хотын үүрэг гүйцэтгэж ирсэн нь түүний байршлаас ихээхэн шалтгаалжээ. Бостон, Вашингтон хоёр төвийн дунд бараг ижил хэмжээний зайд орших энэ хот Гудзон, Ист Ривер 2 голын урсгал нийлэх сав газарт байрладагаараа Атлантын далайд гарах боломжтой ажээ. Нью-Йорк 314 ам бээр газар нутагтай, Бруклин, Бронко, Манхеттан, Куинз, Ричмонд хэмээх 5 хэсэг хотхонөөс бүрдэнэ. Хотхон тус бүр өөрийн өвөрмөц шинж чанараа хадгалахыг эрмэлзсээр иржээ. 4 жилийн хугацаагаар сонгогдох хотын захирагч бөлөн хотын зөвлөлийн 37 гишүүн Нью-Йоркийн удирдлагыг бүрдүүлнэ.

1825 онд нээгдсэн Ейр-Канад усан хоолой хотын хөгжилд ихээхэн нөлөөлсөн байна. Грөйт Лейк нуур, Нью-Йорк хотын боомтын хооронд энэ хоолойгоор хэд хэдэн тонн ачаа зардалбагатай тээвэрлэж эхэлснээр тус хот экспорт, импортын төв болжээ. Жилдээ 26000 завь, хөлөг онгоцны ачаа буулгах хүчин чадалтай Нью-Йоркийн боомт улсын бүх худалдааны 40% гүйцэтгэдэг байна. Худалдаа арилжааны төвийн хувьд 300 төрөл бүрийн мануфактур эрхэлж аж үйлдвэрлэлийн хэмжээгээр дэлхийд тэргүүлэх байр эзэлдэг. Америкийн хөрөнгийн биржээс гадна зарлал сурталчилгааны ихэнх агентлаг, бизнес эрхэлдэг томоохон компаниуд Нью-Йорк хотод өөрсдийн контор, төлөөлөгчийн газраа нээсэн байна.

Тэнгэрт тулсан өндөр барилгууд Манхеттанд төвлөрдөг нь энэ арлын хад чулуун дээр маш хүнд даацын барилга байшин суурилуулах боломжоос гарсан байна. 17-р зууны эхэнд Хенри Гудзон Нью-Йорк хотыг нээж, 1626 онд Голландын Вест Индиа Компани индианчуудаас тэр арлыг бүхэлд нь худалдан авчээ. 1664 онд Англичууд энэ арлыг эзлэн авч бөйс Йоркийг захирагч болгон Нью-Амстердам нэрийг Нью-Йорк болгон сольжээ. Английн 2-р Чарльз хаан бөйс Йоркийн ахын хувьд Америкт байгаа Голландын бүх арлыг эзэмшигчдэд бөйс цол хайрлажээ. Америкийн энэхүү арал Голланд, дараа нь Англи, эцэст нь Америкийнх болсон түүхтэй. Жорж Вашингтон АНУ-ын ерөнхийлөгчийн анхны тангарагийг Нью-Йорк хотноо өргөсөн агаад 1789-1790 оны үед тус хотыг улсын нийслэлээр зарлажээ.

Нью-Йорк хотын боловсролын олон байгууллагаас Колумбийн их сургууль, Нью-Йоркийн их сургууль, Фордамын их сургууль, Хотын их сургууль, Копер Юнион, Жюлиардын хөгжмийн сургууль зэрэг нь онцгой анхаарал

татдаг юм. Театрын хороолол, Линкольны төвийн соёлын цогцолбор зэрэг соёл урлагийн алдарт төвүүд энэ хотод байрладаг.

Төв парк, Нью-Йоркийн Бронкс-зу зэрэг цэцэрлэгт болон амьтдын хүрээлэн ихэд алдаршсан юм. НҮБ-ын төв штаб, 110 давхар 2 цамхагаас бүрдсэн Дэлхийн худалдааны төв, Төр улсын ордон, Рокфеллерын төв, Гэгээн Патрикийн сүм, Стойтен Айландын гармаас харагдах эрх чөлөөний хөшөө, Гарлемийн "хот", Гринвич тосгон, Таймсын талбай, Радио, Хөгжмийн танхим, Хөрөнгийн биржээрээ алдартай Уол-Стрит хороолол зэрэг олон зүйл нь Нью-Йорк хотын сонирхол татахуйц газруудын тоонд ордог.